Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн
86 дугаар тогтоолын 21 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн Боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Эрүүл мэндийн яам | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч | Ахлах түшмэл, ТЗ-9 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII дугаар байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх;
2. Төсөл хөтөлбөрөөр нийлүүлэгдсэн өмч, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, мэдээлэл, ашиглалт, зарцуулалтын явцын хяналт;
3. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааны нарийн бичгийн үүргийг гүйцэтгэх;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх- Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн эрсдлийг тодорхойлж, үнэлгээний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх; | Эрсдлийн үнэлгээ хийгдсэн байна. | Г, Х |
| | 2.Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах; | Хяналт-шинжилгээ, үнэлгээг зохих аргачлалын дагуу хийсэн байна. | Г, Х |
| | 3.Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, санал, зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах. | Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу хийсэн байна. | Г, Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Төсөл хөтөлбөрөөр нийлүүлэгдсэн өмч хөрөнгийн ханган нийлүүлэлт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад дотоод аудитын хийх; | Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу хийсэн байна. | Г, Х |
| | 2.Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалтын нөхцөл байдалд дотоод аудит хийж, санал, зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах. | Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу хийсэн байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны нарийн бичгийн даргын үүргийг | Дотоод аудитын хорооны үйл ажиллагаа хангагдсан байна. | Г, Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | гүйцэтгэх; | | |
| | 2.Дотоод аудитын хорооны жилийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулах. | Дотоод аудитын төлөвлөгөө батлагдсан байна. | Г, Х |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Эрүүл мэндийн яамны удирдлагын шийдвэрээр тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Хяналт-шинжилгээ, үнэлгээг зохих аргачлалын дагуу хийсэн байна. | Г |
| | 2.Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг удирдлагад тайлагнах, мэдээллээр хангах; | Үнэлгээний тайлан мэдээ, дүнг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна. | Г |
| | 3.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах; | Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна. | Г |
| | 4.Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх; | Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль, тогтоомжинд нийцсэн бодитой байна. | Г,Т |
| | 5.Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих; | Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна. | Г |
| | 6.Нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх. | Үүрэг даалгаврыг биелүүлсэн байна. | Х, Г |

**III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:**

| | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх. | |
| Мэргэжил | -эрх зүй /042/;<br>-нягтлан бодох бүртгэл /0411/;<br>-эдийн засаг /0311/;<br>-менежмент ба удирдахуй /041301- 041303/. | |
| Мэргэшил | -Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;<br>-Тухайн чиглэлээр албан ёсны сургалтад хамрагдсан байх. | |
| Туршлага | -Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;<br>-Тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; |

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| | | - тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дэх нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;<br>- нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг зөвлөх;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах;<br>- асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох;<br>- ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах;<br>- хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах;<br>- бусад. |
| | Бусад | - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах;<br>- бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах;<br>- кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх. |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: | |
| Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект:<br>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан хаагч;<br>- Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн; |

| | |
|---|---|
| | - Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын албан хаагч. |
| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br><br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br><br>................................../П.ЭРХЭМБАЯР/<br><br>2022 оны 03 дугаар сарын 15 -ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 22 0301<br>Дугаар: 086 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ<br>Шийдвэрийн огноо: ..........................<br>Дугаар: ...............<br>(тамга/тэмдэг)<br>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА .............................................. /Ц.ЭРДЭМБИЛЭГ/<br><br>2022 оны 03 дугаар сарын 15 -ны өдөр | |

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ